



НИЙСЛЭЛИЙН СОЁЛЫН ТӨВ ӨРГӨӨНИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2020 оны 4 сарын 13 өдөр

Дугаар A/01

Улаанбаатар хот

Г Дүрэм батлах тухай Т

Хөдөмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Засгийн газрын 2017 оны 243 дугаар тогтоол, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын холбогдох заалтуудыг үндэслэн ТУШААХ нь:

1. Соёлын Төв Өргөөний “Албан хаагчдын дагаж мөрдөх хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм”-ийг хавсралтаар баталсугай.
2. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны хангахад зарцуулах хөрөнгийн судалгаа хийж, жил бүрийн төсөвт тусгаж, батлуулахыг ахлах нягтлан бодогч /Ө.Цолモン/-д, дүрмийн хэрэгжилтийн явц, үр дүнг хянаж ажиллахыг албадын дарга нар, дулааны инженер /Ж.Дуламжав/, цахилгааны инженер /Д.Мөнхбаяр/ нарт тус тус даалгасугай.
3. Албадын үйл ажиллагааны чиг үүргийн онцлогтой уялдуулан хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дагаж мөрдөх журам, зааварчилгаа гаргаж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг зөвшөөрсүгэй.

ЗАХИРАЛ 
Б.БАЙГАЛМАА

Нийслэлийн Соёлын төв өргөөний
захирлын барын дугаар сарын
13. өдрийн 10. дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт

АЛБАН ХААГЧДЫН ДАГАЖ МӨРДӨХ ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Дүрмийн зорилго нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх хууль, тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулж, эрсдэлгүй, аюулгүй, эрүүл ажлын байрны орчинг бурдүүлэх, ажиллагаачдыг эрүүл, аюулгүй орчинд хөдөлмөрлөх эрхийг хангдуулж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тохиолдлыг бууруулахад оршино.
- 1.2. Галын аюулгүй байдал, байгалийн давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалсан гамшгийг Галын аюулгүй байдлын, Гамшгаас хамгаалах тухай хууль, журмаар зохицуулна.
- 1.3. Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүргийг ажил олгоч шууд хариуцна.
- 1.4. Байгууллагын үйл ажиллагааны өвөрмөц онцлогтой холбоотойгоор албадууд эрүүл, аюулгүй ажиллагааны талаар хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, дагаж мөрдөх заавартай байна.

Хоёр. Хөдөлмөрийн аюулгүй байдал, Эрүүл ахуйн талаар ажил олгогчийн үүрэг

- 2.1. Ажлын байрны хөдөлмөрийн эрүүл ахуй, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байх нөхцөлийг бурдүүлэх, техник, зохион байгуулалтын арга хэмжээ авах;
- 2.2. Хөдөлмөр эрхлэлтийн явцад гарч болзошгүй осол, бэртэл, өвчлөлөөс ажилтныг хамгаалах, бий болсон тохиолдолд уг үйл ажиллагааг яаралтай зогсоож, аюултай нөхцөл байдлыг шуурхай арилгах;
- 2.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоо нэвтрүүлэх;
- 2.4. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг хийлгэх;
- 2.5. Ажлын байрны онцлогт нийцсэн дүрэм, заавар, журам баталж, мөрдүүлэх;
- 2.6. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар шаардлагатай мэдлэгийг эзэмшүүлэх, талаар хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрт тусгаж, хэрэгжүүлэх;
- 2.7. Аюулгүй ажиллагааны мэдлэг олгох сургалт явуулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи мэдлэгийг жил бүр шалгах, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх, сургалтад хамрагдаагүй, зааварчилгаа аваагүй, шалгалт өгөөгүй ажилтнаар ажил үүрэг гүйцэтгүүлэхгүй байх;
- 2.8. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий этгээдийг ажлын байранд саадгүй нэвтрүүлэх;
- 2.9. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлийг хангах арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусгаж, батлуулах,

- 2.10. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогын улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан ажилтанд хууль тогтоомжийн дагуу нөхөн төлбөр олгох;

Гурав. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар ажил олгогчийн дараах эрхтэй.

- 3.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан зөвлөл байгуулах, ажилтныг ажилд томилох, ажлаас чөлөөлөх;
- 3.2. Ажил олгогч нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтэц болон ажилтан ажиллуулах орон тоонд хүрээгүй тохиолдолд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг мэргэшсэн байгууллага, ажилтнаар гэрээгээр гүйцэтгүүлж болно.
- 3.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээнд батлагдсан төсвийг дараах арга хэмжээнд зарцуулна.
 - 3.3.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, сурталчилгаа;
 - 3.3.2 Ажилтныг эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгт хамруулах;
 - 3.3.3 Ажилтныг сувилах, хөдөлмөрийн чадвар алдалтыг нөхөн сэргээх;
 - 3.3.4 Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл;
 - 3.3.5 Ажлын байр, үйлдвэрлэлийн орчны аюул, эрсдэлгүй байдлыг хангах;
 - 3.3.6 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх бусад арга хэмжээ.

Дөрөв. Үзэгч, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах.

- 4.1. Их танхимд зохион байгуулагдаж байгаа тоглолт, арга хэмжээнд оролцож байгаа уран бүтээлчид, үзэгч, үйлчлүүлэгчийн аюулгүй байдалд Уран бүтээл техникийн, Маркетинг үйлчилгээний албаны албан хаагчид, жижүүр, цахилгаанчин, ээлжийн диспетчер нар хамтран ажиллаж, байнга хяналт тавьж ажиллана.
- 4.2. Байгууллагын “Албан хаагчдын дагаж мөрдөх хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм”-ийн 1.2-т заасан нөхцөл, байдал үүсвэл удирдлагад яаралтай мэдэгдэж, шуурхай арга хэмжээ авч ажиллана.

Тав. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага.

- 5.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, дүрмийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.
- 5.2. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.
- 5.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль, дүрэм, журмыг зөрчсөн ажилтан байгууллагад эд хөрөнгийн хохирол учруулсан тохиолдолд хөдөлмөрийн дотоод журмын 4.8 заасан хариуцлага хүлээнэ.
- 5.4. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлаар ажил олгогч, ажилтан болон хөдөлмөр эрхэлж буй этгээдийн хооронд үүссэн маргааныг холбогдох хуулийн дагуу шийдвэрлэнэ.

-----оОо-----